

Та ажил хайгаад амжилтад хүрэхгүй байна уу?

CV-гээ зөв бичээрэй!

Намтар (CV) бол таны ажлын туршлагын хураангуй бөгөөд ажил хайхад маш их тус болно.

Та өөрийн намтраа хэрхэн харагдахыг олон хэлбэрээр олох боломжтой. Ямар ч тохиолдолд энэ нь тодорхой бөгөөд товч байх ёстой. Намтар нь хоёр А4 хуудаснаас хэтрэхгүй байх ёстой.

Гэхдээ ямар мэдээллүүдийг намтартаа бичих вэ?



- *Холбоо барих мэдээлэл* (нэр, овог, академийн цол, гэрийн хаяг, утас, цахим хаяг, төрсөн огноо - хүсвэл бичиж болно, мөн та өөрийн зургаа хавсаргаж болно)



- *Ажлын туршлага* (хамгийн сүүлийн ажлаасаа хамгийн эртнийх хүртэл он цагийн дарааллаар эрэмбэлж, хөдөлмөрийн харилцаа хэзээнээс хэзээ хүртэл үргэлжилснийг бичиж мөн ажлын талаар товч тодорхой бичнэ үү)



- *Эзэмшсэн боловсрол* (эзэмшсэн хамгийн дээд боловсролын төгссөн жил болон мэргэжлээ бичнэ. Хэрэв та гадаадад эзэмшсэн боловсролоо Чех Улсад харьцуулж nostrifikace хийлгэсэн бол энэ тухай бичихийг зөвлөж байна. Мөн гадаадад төгссөн курс, сургалт, дадлагаа бичнэ үү.)



- *Ур чадвар болон дадлага туршлага*



- *Хэлний мэдлэг*



- *Компьютер дээр ажиллах чадвар*

- *Та жолооны үнэмлэхтэй юу? Үүнийг бас бичих хэрэгтэй. Гэхдээ та идэвхтэй эсвэл идэвхгүй жолооч эсэхээ бичихээ бүү мартаарай.*



- *Сонирхол болон хобби.*

Та хөдөлмөрийн зах зээлд чөлөөтэй эсвэл болзолтой нэвтрэх боломжтой эсэхээ намтартаа дурдахыг зөвлөж байна.



Юуг мартаж болохгүй вэ?

- Зөвхөн үнэн мэдээлэл өгөх.
- Зөв дүрмээр бичих нь чухал. Илгээхээсээ өмнө намтраа шалгаарай.

Хэрэв та намтраа цахим хаягаар илгээж байгаа бол үр чадварын захидал хавсаргах нь зүйтэй. Үр чадварын захидалд та яагаад энэхүү ажлыг сонирхож байгаа, яагаад та энэхүү ажилд зөв нэр дэвшигч болох талаар илүү дэлгэрэнгүй тайлбарлаж болно. Үр чадварын захидал нь намтрын өргөтгөл тул доторх мэдээллийг давтах шаардлагагүй. Энэ нь 3-6 богино догол мөртэй байх ёстой. Үр чадварын захидалдаа мэндчилгээ болон талархал мөн салах ёс бичихээ бүү мартаарай.



FINANCOVÁNO
EVROPSKOU UNÍÍ
AZYLOVÝ, MIGRAČNÍ
A INTEGRAČNÍ FOND



MINISTERSTVO VNITRA
ČESKÉ REPUBLIKY



Projekt "Centrum na podporu integrace cizinců v Ústeckém kraji" AMIF/31/03 je financován Evropskou unií v rámci národního programu Azylového, migračního a integračního fondu a rozpočtu Ministerstva vnitra České republiky.